



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 25/96

Улаанбаатар хот

Г Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоот
үйлдвэрийн газруудын ашиг орлогын
хуваарилалт тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, 77 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын 2024 оны санхүүгийн тайлангийн цэвэр ашгаас 2025 онд нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь, хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Төсөвт төвлөрүүлэхээр тооцсон нийт 1,307,361,100.00 (нэг тэрбум гурван зуун долоон сая гурван зуун жаран нэгэн мянга нэг зуу) төгрөгийн ногдол ашгийг 2025 онд багтаан нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсөв, хөрөнгө оруулалтын хороо (Ж.Сандагсүрэн)-нд даалгасугай.

ДАРГА

А.БАЯР

1725010042

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн
 2025.07.08 дугаар тогтоолын хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ОЙ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРУУДААС
 НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ НОГДОЛ АШИГ

№	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нэрс	Ашиг алдагдал		Татвар төлсний дараах цэвэр ашиг	Ногдол ашгийн дүн	Орлогын албан татвар 10%	Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх дүн
		2024 оны зорилт	2024 оны гүйцэтгэл				
1	Зорчигч тээвэр гурав	(7,178,238.7)	5,453,021.6	4,907,719.44	500,000.00	50,000.00	450,000.00
2	Зорчигч тээвэр дөрөв	(1,234,361.7)	2,797,683.1	2,799,628.70	500,000.00	50,000.00	450,000.00
3	Зорчигч тээвэр тав	(4,755,593.6)	229,336.4	206,402.80	103,201.40	10,320.14	92,881.26
4	Хүнс хангамж төв	26,966.4	159,377.8	150,858.20	75,429.10	7,542.91	67,886.19
5	Өсвөр үе хүнс	8,487.2	199,511.4	174,504.60	87,252.30	8,725.23	78,527.07
6	Гэрлэх ёслолын ордон	18,835.2	203,219.0	167,598.90	83,799.45	8,379.95	75,419.51
7	УБ зам засвар, арчлалтын газар	49,081.2	42,875.6	38,588.10	19,294.05	1,929.41	17,364.65
8	Багачууд хүнс	72,201.9	185,882.2	167,293.98	83,646.99	8,364.70	75,282.29
ОНӨААТҮГ-ЫН ДҮН		-15,998,679.3	20,563,810.6	16,778,731.2	1,452,623.3	145,262.3	1,307,361.0